

БАТЛАВ.
ТУУЛ ГОЛЫН САВ ТАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
Я.БОЛДБААТАР/
2017 оны 6 дугаар сарын 09
5633-48
УЖАУУ53

БАТЛАВ
ХОС ХАС-ХХК
"ХОС ХАС" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Б.ТЭНГИС/
2017 оны 6 дугаар сарын 09
1116226325 дк. 2100231
УЛААНБААТАР ХОТ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар - 29

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Монгол-Ус" ТӨҮГ-ын захирлын "Дүгнэлт хүргүүлэх тухай" 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 1/200 тоот, Туул голын сав газрын захирагааны даргын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-47 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлеөлж Туул голын сав газрын захирагааны Ус ашиглалтыг зохицуулах албаны уул уурхай, эрчим хүчиний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сүхбат, Ус ашиглагчийг төлеөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Жамъян гүний гудамж, 5-206 тоотод байрлах улсын бүртгэлийн 9011064046 тоот гэрчилгээ, 2100231 тоот регистрийн дугаартай "Хос хас" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Тэнгис нар ус ашиглах талаар тохиролцож энэхүү гэрээг 2017 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нехцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-008866 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Өгөөмерийн алтны шороон орд"-ын техник, технологийн болон хүн амын унд, ахуйн хэрэгцээнд усны неөвцийг ашиглана.

2.1.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2014 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн A05 дугаар тушаалаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3.3-т заасны дагуу 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захирагаанаас төлеөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 121'237 м³ элс угаахад зарцуулах ус 484'948 м³/жил

2.2.1. Үнд-ахуйд: 3255 м³/жил

2.2.2. Үйлдвэрлэлд нөхөн сэлбэлтээр ашиглах усны хэмжээ: 129'280 м³/жил

2.2.3. Зам, талбайн усалгаанд шаардагдах ус: 31661 м³/жил

2.3. Усны чанар, найрлага: 2017 оны 7 дугаар сарын 25, 10 дугаар сарын 05-ны дотор гүний худаг болон хаягдлын нуурнаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг Туул голын сав газрын захирагаанд ус ашиглалтын тайлангийн хамт ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэр:

2.4.1. Байршил: Үнд-ахуйн усны хэрэгцээг 40 м гүнтэй, 1 л/сек ундаргатай гүний худгаас, технологийн хэрэгцээний усиг Туул голын уснаас нөхөн сэлбэлтээр ашиглана. Худгийн байршил: 104° 30' 39", 48° 25' 33", Туул голоос ус авах цэгийн байршил: 104° 30' 46.54", 48° 23' 54.04"

2.4.2. Барилга байгууламж: Усан сан 18000 м³, тунгаах сан 24000 м³ зэлзэхүүнтэй. Туул голоос усан сан хүртэл 159 мм диаметртэй 520 м урт, усан сангаас угаах төхөөрөмж рүү 350 мм диаметртэй 100 м урттай ган хоолойгоор ус татна.

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: 80 м³/цаг хүчин чадалтай Screen-80 маркийн 1 угаах төхөөрөмж ашиглана.

2.4.4. Насосны хүчин чадал: Гүний худагт QJ110PE маркийн насос, Туул голоос усан сан руу Д-200/30 маркийн насос, усан сангаас угаах төхөөрөмж рүү Д-320/50 маркийн 2, нийт 3 насос сууринуулсан.

2.5. Хаягдал усны хэмжээ: Ахуйн хаягдал бохир усны хэмжээ 3175 м³/жил.

2.5.1. Стандартын шаардлага: Үйлдвэрлэлээс гарах технологийн хаягдал болон ахуйн бохир усиг цэвэршуулэх хүрэлзэн буй орчинд нийлуулэхдээ Хаягдал усны стандарт (MNS-4943:2011)-ын шаардлагыг мөрдлөг болгоно.

2.5.2. Хаях цэгийн байршил: Ахуйн бохир усиг уурхайн тосгоны хашаанд байрлах бохирын цооногт хуримтуулан хөрсөнд шингээн зайлцуулна. Технологийн хэрэгцээнд ашигласан усиг тунгаагуурт тунгааж, эргүүлэн ашиглана.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: 2017 оны 7 дугаар сарын 25, 10 дугаар сарын 05-ны дотор гүний худаг болон хаягдлын нуурнаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээний хийлгэн, шинжилгээний дүнг Туул голын сав газрын захиргаанд ус ашиглалтын тайлангийн хамт ирүүлнэ.

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Технологийн хаягдал усиг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны неөөц хомсдох, бохирдохooс сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуур: Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Туул голоос ус татаж буй насосны гаралт дээр 2016 оны 06 дугаар сарын 02-ны усны тоолуур сууринуулж, лац тавьсан тэмдэглэл үйлдсэн.

2.10. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

2.10.1. Урьдчилсан байдлаар нехөн сэлбэлтээр ашиглах 129'28 м³ усны төлбөрт 30'846'208 /гучин сая найман зуун дечин зургаан мянга хоёр зуун найм/ төгрөг, зам, талбайн усалгаанд ашиглах 31'661 м³ усны төлбөрт 2'517'050 /хоёр сая таван зуун арван долоон мянга тавь/ төгрөг, нийт 33'363'258 /гучин гурван сая гурван зуун жаран гурван мянга хоёр зуун тавин найм/ төгрөгийг Булган аймгийн Төрийн сан банкны 040000944 тоот дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 20 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 40 хувийг деревдүгээр улиралд төлнэ.

2.10.2. Байгалийн неөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг төвлөрүүлэхдээ тоолуурын заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлтээр тогтоосон төлбөрийн хувь хэмжээгээр тооцож, орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулах бөгөөд усны тоолуур сууринуулахаас өмнөх ус ашиглалтын хэмжээг уулын ажлын тайланг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхдээ зарцуулах усны норм"-ын дагуу тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг

хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг ажлын 14 хоногт багтаан дүгнэж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцэлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцэлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ
ТӨЛӨӨЛЖ:

Ус ашиглалтыг зохицуулах албаны
дарга

 /Ю.Сувдчимзэг/

Мэдээлэл, хяналт үнэлгээний албаны
дарга

 /Б.Оюунболд/

Ус ашиглалтыг зохицуулах албаны уул
урхай, эрчим хүчиний ус ашиглалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

 /С.Сүхбат/

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,
2-р хороо, Чингүнжавын гудамж,
Туул голын сав газрын захирагааны
байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө
Харилцах утас: 363716, 363714, 362592

"ХОС ХАС ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гүйцэтгэх захирав:

 /Б.Тэнгис/

Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар
дүүрэгийн 1-р хороо, Жамъян гүний гудамж,
"Буюнпил" ХХК-ийн байр, 206 тоот
Харилцах утас: 99998907, 94760896,
320142